

ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР БАЙГУУЛЛАГЫН ИЛ ТОД БАЙДЛЫН ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТИЙН 2018 ОНЫ ХЭРЭГЖИЛТЭД ХИЙСЭН ХЯНАЛТ- ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ АЖЛЫН ТАЙЛАН


Дундговь аймгийн нутгийн захиргааны байгууллагын үйл ажиллагааны ил тод нээлттэй байдлыг хангах талаар зохион байгуулсан ажлыг Засгийн газрын 2017 оны 89 дүгээр тогтоолоор баталсан журмын хавсралт “Байгууллагын ил тод байдлыг илтгэх шалгуур үзүүлэлт”-ийн дагуу хэрэгжилтийг нэгтгэн гаргаж хяналт шинжилгээ хийж ажиллалаа.

Аймгийн хэмжээнд байгууллагын ил тод нээлттэй байдлыг хангах чиглэлээр удирдлага, зохион байгуулалтын нилээдгүй арга хэмжээ авч хэрэгжүүлсэнээс гол ажлуудыг дурдвал: Төсвийн, Шилэн дансны, ТХБАҮХАТХ хуулийг хэрэгжүүлэх чиглэлээр төрийн албан хаагчдад үе шаттай сургалтуудыг зохион байгуулсан. Бүх байгууллагыг Вэб сайттай болгон аймгийн сайтад холбоос үүсгэсэн. Жил бүр төрийн албан хаагчид болон шат шатны байгууллагын удирдлагууд “Авлигаас ангид байх амлалт”-ыг гарын үсгээр баталгаажуулан үр дүнгийн гэрээний хавсралт болгон хэрэгжүүлдэг. Аливаа сонгон шалгаруулалтыг нийтэд ил тод мэдээлэх ажлыг хэвлэл мэдээллийн олон хэлбэрээр ил тод мэдээлж ажилласан. Байгууллага бүр ил тод байдлыг хангах “Самбар”-тай болж мэдээллээ шинэчлэхэд ахиц гарсан байна. Иргэдийн өргөдөл санал хүсэлтийг “7059106” утас, бичгээр, амаар, хайрцгаар, санал асуулгаар, цахимаар, уулзалт, хэлэлцүүлгээр зэрэг олон хэлбэрийг ашиглан авах, сонсох ажлыг хэрэгжүүлэн ажиллаж байна.

Аймгийн www.dundgovi.gov.mn цахим хуудас, фэйсбүүк хуудас, бусад вэб сайтууд, телевиз, радио, шторк хэлбэрээр мэдээллийн олон талт сувгуудаар олон нийтэд сурталчилсан ба мэдээллийн самбарт мэдээллүүдийг байршуулж, 2018 онд ил тод нээлттэй байдлыг хангаж, “Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай” хууль болон Засгийн газрын 2009 оны 143 дугаар тогтоолын хэрэгжилтийг хангах чиглэлээр цөөнгүй ажлыг хийж гүйцэтгэлээ. Байгууллагын ил тод байдлын хэрэгжилтэд 2018 оны 7 сар, 12 сард явцын үнэлгээ хийж, Төрийн захиргааны удирдлагын хэлтэст зөвлөмж өгч хэрэгжилтийг тооцон ажиллалаа.

Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын хэлтсийн 2018 оны ажлын төлөвлөгөөнд тусгасан удирдамжийн дагуу 21 хэлтэс, газар, 15 сумдаар явцын болон гүйцэтгэлийн хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, зөвлөн туслах ажлыг зохион байгуулан ажиллалаа.

Сумдын болон хэлтэс агентлагийн жилийн эцсийн ажлыг дүгнэх 12 үзүүлэлтэд Ил тод байдлын үнэлгээний биелэлтийг хамааруулан тооцож дүгнэсэн нь хэрэгжилтэд ахиц өөрчлөлт гарахад түлхэц боллоо.



**Байгууллагын ил тод байдлыг илтгэх шалгуур үзүүлэлтийн биелэлтийн дүнгийн
ТОВЧОО**

№	Шалгуур үзүүлэлт	Заалтын тоо	Хэрэгжилтийн хувь					Нийт хэрэгжилтийн хувь
			100	70	30	0	ҮБ	
1	Үйл ажиллагааны ил тод, нээлттэй байдал	9	8	1				96,6
2	Хүний нөөцийн бодлогын ил тод байдал	5	4	1				94
	Дүн	14	12	2				95,3

Байгууллагын ил тод байдлын хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх ажлыг жилд 3 удаа хийж, ажил эрчимжүүлэх зөвлөмж өгсний үр дүнд иргэдэд хүрэх мэдээ мэдээллийн хүртээмж нэмэгдэж, ажлын чанар, гүйцэтгэл сайжирч байна. Цаг үеийн мэдээ, мэдээллийг цаг алдалгүй тогтмол байршуулж, иргэдийн хандалт өндөртэй сүлжээнд холбон мэдээлэл хүргэж, малчид иргэдэд АС цогцолбороор, орон нутгийн АРД телевизээр түгээж байгаа нь сайшаалтай байна.

Үйлчилгээ авахад шаардагдах бичиг баримтын жагсаалт, сул орон тооны зар, албан хаагчийн ёс зүйн дүрэм, мэдээллийн самбарын хөтлөлт зэрэг нь өмнөх жилүүдээс сайжирсан байна. Үүний хажуугаар мэдээ, мэдээлэл байршуулдаг ажилтнаас гадна ил тод байдлын шалгуур үзүүлэлтийн дагуух мэдээллийг байршуулах админ тодорхойгүй байгаад анхаарч ажиллах шаардлагатай байна.

Цаашид авч хэрэгжүүлэх санал зөвлөмж

Аймгийн түвшинд:

Байгууллагын үйл ажиллагааны ил тод байдлын мэдээллийг авч нэгтгэн байршуулдаг ажилтныг томилон ажлын байрны тодорхойлолтод чиг үүргийг тусган эзэнжүүлж, тайлан гаргах, хавсралт материал цуглуулж баримтжуулж ажлыг чанартай гүйцэтгэж зохион байгуулах шаардлагатай байна.

Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хуулийн 7.1-д заасан үүргийг хэрэгжүүлэх үйл ажиллагааг тогтмолжуулж, дутуу байршуулсан зарим мэдээллийг нэмж оруулах. Үүнд:

- Үйл ажиллагаандаа мөрдөж байгаа хууль тогтоомж, дүрэм, журам, зааврыг хэлтэс бүр шинэчлэн, цахим хуудас болон мэдээллийн самбартаа ойлгомжтой байдлаар байрлуулан тухай бүр шинэчлэх;
- Шинээр боловсруулж байгаа бодлогын баримт бичиг болон нийтээр дагаж мөрдөх хэм хэмжээ тогтоосон шийдвэрийн төслийг цахим хуудсандаа 30-аас доошгүй хоног ойлгомжтой байдлаар байрлуулж, холбогдох төрийн ба төрийн бус байгууллага, мэргэжлийн шинжээч, эрдэмтэн, иргэдийн саналыг авах, үндэслэлтэй гэж үзвэл уг саналыг төсөлд тусгах;
- Төрийн байгууллагын гүйцэтгэх тодорхой чиг үүргийг төрийн бус байгууллага гүйцэтгэж байгаа талаарх мэдээлэл хангалтгүй байгаа тул тэдгээр төрийн бус байгууллагын

нэр, хаяг, цахим хуудас, эрхэлж байгаа үйл ажиллагааны чиглэлийн талаарх мэдээллийг хэлтсүүдээс цуглуулан нэгтгэж байршуулах;

-Үзүүлж байгаа үйлчилгээний арга, хэлбэрийг боловсронгуй болгох зохион байгуулалтын арга хэмжээ авч хэрэгжүүлэх;

-Улсын төсвийн хөрөнгөөр болон гадаадын зээл, тусламжаар хэрэгжүүлж байгаа төсөл хөтөлбөрийн хэрэгжилт, явц, байдлын талаарх мэдээллийг хэлтсүүдээс цуглуулан цахим хуудсанд байрлуулах;

-Албан хаагчдын ажлын гүйцэтгэлийг үнэлэх үйл ажиллагааг үнэн зөв, шударга болгох чиглэлээр авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээний талаар цахим хуудсанд ойлгомжтой байдлаар байрлуулах, мөн самбараар мэдээлж байх;

ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ ДОТООД АУДИТЫН ХЭЛТЭС